



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЪЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2018 оны 12 сарын 10 өдөр

Дугаар А/415

Улаанбаатар хот

Зарим албан хаагчдад мөнгөн тусламж
олгох тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, Байгууллагын даргын 2017 оны А/441 дүгээр тушаалаар баталсан "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 8.11.7-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ердийн галлагаатай гэр, орон сууцанд амьдардаг хавсралтад дурдсан 24 ажилтан, албан хаагчдад тус бүр 100.000 /нэг зуун мянга/ төгрөгийн мөнгөн тусламж олгосугай.

2. Тусламжид шаардагдах 2.400.000 /хоёр сая дөрвөн зуун мянга/ төгрөгийг холбогдох зардлаас тооцож олгохыг Санхүүгийн хэлтэс /Б.Даваажав/-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар /Д.Давааням/-т даалгасугай.

ДАРГА



Д.МӨРӨН

000001675